



УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 1/06

Улаанбаатар хот

Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх хэсэг, Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/43 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын "Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай" 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/223 дугаар захирамж, УБИС-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.17 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ төрлийн коронавируст халдвартын дэгдэлт дэлхийн улс орнуудад хурдтай тархаж байгаатай холбогдуулан УБИС-ийн хэмжээнд халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах үүрэг бүхий шуурхай багийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хийх ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 03 дугаар сарын 30-ны өдрийг дуустал сунгасантай холбогдуулан сургуулийн байранд олон нийтийг хамарсан ямар нэг арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг шуурхай багийн бүрэлдэхүүн, тэнхим, нэгжийн эрхлэгч нарт даалгасугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан УБИС-ийн нийт багш, ажилтан нарыг гадаад улс орон руу томилолтоор зорчихыг хөл хорионы хугацааг дуустал зогсоосугай.

4. Сургалтын хөтөлбөрийг цахимаар хэрэгжүүлэхтэй холбогдуулан бүх түвшний сургалтын хөтөлбөрийн бэлтгэл ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг сургалт эрхэлсэн дэд захирал /Г.Анхбаяр/-д, багш, оюутнуудын хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулалгүй хөтөлбөр, хуваарийн дагуу зохион байгуулж, байнгын мэдээлэл солилцож, шуурхай арга хэмжээ авч ажиллахыг бакалаврын сургалтын алба /нийт мэргэжилтнүүд/ болон магистр, докторын сургалтын алба /Х.Сүглэгмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

5. УБИС-ийн нийт оюутан, багш ажилтанд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаагаа сайжруулах чиглэлээр Засгийн газар, ЭМЯ, ДЭМБ, БСШУСЯ, бусад холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөгөө, мэдээллээр хангах, шуурхай багийн бүрэлдэхүүнийг удирдлага, чиглэлээр хангаж ажиллахыг шуурхай багийн ахлагч, хүний нөөцийн албаны дарга /Б.Энхбаатар/-д даалгасугай.

6. Аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг зохих журмын дагуу тасалдуулахгүй явуулж, хөл хорионы хугацаанд багш, ажилтнуудын цалинг зохих ёсоор олгохыг санхүү, эдийн засгийн албаны дарга, нягтлан бодогч /О.Туяа/-д зөвшөөрсүгэй.

13201050

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хүний нөөцийн албаны дарга /Б.Энхбаатар/-д, ажил үүрэгтээ мөрдлөг болгож ажиллахыг нэгжийн удирдлагууд, нийт багш ажилтнуудад үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



(Sc.D), проф С.БАЙГАЛСАЙХАН



Хөл хорио тогтоосон хугацаанд хариуцлагатай
жижүүрээр ажиллах шуурхай багийн бүрэлдэхүүн

д/д	Овог нэр	Албан тушаал	Хариуцлагатай жижүүр хийх хугацаа	Утасны дугаар
1	Б.Энхбаатар	Хүний нөөцийн албаны дарга	2020.02.10- 2020.02.14	11-453567, 88104940
2	Г.Анхбаяр	Сургалт эрхэлсэн дэд захирал	2020.02.17- 2020.02.21	11-456360, 99892298
3	С.Цолмон	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал	2020.02.24- 2020.02.28	11-453554, 99150021
4	О.Туяа	Санхүү, эдийн засгийн албаны дарга	2020.03.02- 2020.03.08	11-457049
5	Д.Ганцогт	Чанарын дотоод баталгаажуулалт, маркетингийн албаны дарга	2020.03.09- 2020.03.13	88081245
6	Х.Сүглэгмаа	Магистр, докторын сургалтын албаны дарга	2020.03.16- 2020.03.20	11-458331 99099604
7	Л.Бат-Эрдэнэ	Аж ахуйн дарга	2020.03.23- 2020.03.27	11-458322 99088980
8	Ц.Отгонжаргал	Багшийн хөгжлийн төвийн эрхлэгч	2020.03.30- 2020.04.03	91992713

ЖИЧ: Тус хугацаанд шуурхай багийн бүрэлдэхүүн нь тухайн хариуцсан 7 хоногтоо тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажил үйлчилгээ болон онлайн хичээл сургалтыг тасалдуулахгүй явуулах нөхцөл бололцоог хангаж, холбогдох тэнхим, алба, нэгжүүдийг мэдээллээр хангаж, шаардлагатай тохиолдолд шуурхай багийг цуглуулж асуудлыг шийдвэрлүүлэх үүргийг хүлээнэ.



Улаанбаатарын их сургуулийн
захирлын 2020 оны 02 дугаар сарын 04.-ны
өдрийн 10/06 тоот тушаалын 7 дугаар хавсралт
их сүнгууль

9596558 1157743063

Хөл хороо тогтоосон хугацаанд хариуцлагатай
жижүүрийн хийх ажлын төлөвлөгөө

д/д	Ажиллах чиглэл	Хариуцах эзэн, /овог нэр, албан тушаал/	Хамрах хүрээ	Хийх ажил
1	Цахим сургалт /онлайн хичээл/	Г.Анхбаяр – сургалт эрхэлсэн дэд захирал 11-456360, 99892298 Х.Сүглэгмаа – магистр докторын сургалтын албаны дарга	Бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн багш, оюутнууд	Онлайн хичээлийн бэлтгэл хангах, 03.02-ноос 03.30-ныг дуустал хичээл, сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулна.
2	Аж ахуйн үйлчилгээ, цэвэрлэгээ	О.Туяа- Санхүү, эдийн засгийн албаны дарга 11-457049, 99041988 Л.Бат-Эрдэнэ – Аж ахуйн дарга 11-458322, 99088980	Сургуулийн байрны гадна болон доторх орчин	Халдвартай жүүлэлт, ариутлагын цэвэрлэгээг тогтмол хийлгэх,
3	Эрдэм шинжилгээ, гадаад, дотоод харилцааны чиглэлээр	С.Цолмон – Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал 11-453554, 99150021	Гадаад оюутан, багш нар	Хөл хорооны хугацаанд гадаад оюутан, багш нарын гарах орох виз, оршин суух зөвшөөрлийн асуудлыг зохих журам, шийдвэрийн дагуу шуурхай зохион байгуулах
4	Хариуцлагатай жижүүр гарган ажиллах,	Б.Энхбаатар – Хүний нөөцийн албаны дарга 11-453567, 88104940 Д.Ганцогт – Дотоод чанарын баталгаажуулалтын албаны дарга 88081245	Бүх нэгжийн удирдлагууд, захиргаа, аж ахуйн ажилтнууд,	Хөл хорооны хугацаанд, ялангуяа Цагаан сарын баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүр гаргаж, сургуулийн байранд хяналт тавьж ажиллах
5	ЗГ, БСШУСЯ, Бусад холбогдох байгууллагуудаас ирүүлсэн чиглэл, тогтоол тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах	Б.Энхбаатар – Хүний нөөцийн албаны дарга 11-453567, 88104940	Нийт бүрэлдэхүүн	Сургуулийн нийт бүрэлдэхүүнд цаг тухай бүрт мэдээ, мэдээллээр хангаж ажиллах
6	Мэдээлэл, харилцаа, холбоо	Б.Энхбаатар – Хүний нөөцийн албаны дарга Ц.Отгонжаргал – багшийн хөгжлийн төвийн эрхлэгч	Мэдээллийн технологийн алба, БСА, МДСА, НС	Онлайн хичээл болон бусад чиглэлээр мэдээлэл, технологийн асуудлыг шуурхай шийдвэрлэн ажиллана.